




2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Шинэ үнэт цаас болон ХК-ийн бүртгэл



2020 оны эхний хагас жилд Монголын хөрөнгийн биржид **шинээр үнэт цаас бүртгүүлэхээр 1 ХК** хүсэлтээ ирүүлсэнийг судалж, Санхүүгийн Зохицуулах Хороонд холбогдох шийдвэр, дүгнэлтийг хүргүүлсэн. Харин 2019 онд СЗХ-ны холбогдох шийдвэр гарсан **“Бодь даатгал” ХК нь** МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар **нийт 5.3 тэрбум төгрөгийг** олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн.

Компанийн бонд – Өрийн хэрэгсэл



Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй **2 ХК-үүд** шинээр өрийн хэрэгсэл гаргахаар хүсэлт ирүүлсэнээс, **“Лэндмн ББСБ” ХК-ийн 50,000 ширхэг** бонд шинээр бүртгэгдэж, анхдагч зах зээлийн арилжаагаар **нийт 5.0 тэрбум төгрөгийг** олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн ба **бондын өгөөж жилийн 17%**, хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэн. Харин **1 ХК-ийн** хүсэлтийг МХБ судалж, шалгаж байгаа болно.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Бүртгэлийн өөрчлөлт–Нэмэлт хувьцаа

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй **2 ХК–үүд нэмэлт үнэт цаас гаргахаар хүсэлт** ирүүлсэнийг тус тус судалж, **нийт 185,350,910 ширхэг** үнэт цаасыг нэмж бүртгэн, Санхүүгийн Зохицуулах Хороонд холбогдох шийдвэр, дүгнэлтийг хүргүүлсэн. Үүнд:


“Сүү” ХК – олон нийтээс **18.6 тэрбум төгрөг** татан төвлөрүүлэхийг СЗХ зөвшөөрсөн бөгөөд МХБ дээр анхдагч зах зээлийн арилжааны захиалга нээгдэхээр хүлээгдэж байна.

“Дулааны II ЦС” ХК – хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдаас **9.98 тэрбум төгрөгөөр** хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх талаар МХБ–ийн холбогдох дүгнэлтийг СЗХ–нд хүргүүлсэн.



Бүртгэлийн өөрчлөлт–Хувьцаа хуваах

“Дархан нэхий” ХК нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаагаа хувааж, бүртгүүлэхээр хүсэлтээ ирүүлсэнийг судалж, нийт **бүртгэлтэй 1,105,479 ширхэг үнэт цаасыг 1,105,479,000 ширхэгт хуваан 2020 оны 7 сарын 1–ний өдөр шинэчлэн бүртгэв.**





ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ



Бүртгэлтэй компанийн нэгдэл

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Хархорум Пропертийс” ХК-д нэгдэх “Эрдэнэс Сольюшинс” ХК-ийн хүсэлт Санхүүгийн Зохицуулах Хороонд 2020 оны 2 дугаар сард хүлээн зөвшөөрөгдснөөр түүний 15,751,262 ширхэг үнэт цаас МХБ-д бүртгэгдсэн.



Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх

1 хөрөнгө оруулалтын сан гаргасан нэгж эрхээ МХБ-д бүртгүүлж, нийтэд арилжих хүсэлт ирүүлсэнийг МХБ судалж, шалгаж байна.



Засгийн газрын үнэт цаас

Тайлант хугацаанд Сангийн яамнаас дотоодын зах зээлд Засгийн газрын үнэт цаас гаргахгүй байх төсөв, санхүүгийн бодлогыг баримталсантай холбоотой биржид шинээр нэмж ЗГҮЦ-ыг бүртгээгүй буюу анхдагч зах зээлийн арилжаа огт явагдаагүй. Харин 20.2 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдэж 201,894 ширхэг ЗГҮЦ-ыг биржийн бүртгэлээс хассан.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Биржийн гишүүн ҮЦК



2020 оны эхний хагас жилд 2 ҮЦК-уудын хүсэлтийн дагуу Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн холбогдох шийдвэрээр “Райнос Инвестмент ҮЦК” ХХК-ийг биржид шинээр гишүүнээр элсэж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон “Капитал Маркет Корпораци ҮЦК” ХХК-ийг биржийн гишүүнчлэлээс хассанаар нийт 59 үнэт цаасны компани болон 4 кастодиан банк үйл ажиллагаа явуулж байна.

ЖУРМЫН ШИНЭЧЛЭЛТҮҮД

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам

МХБ-ийн “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг шинээр боловсруулж, батлуулан, СЗХ-ны даргын 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 146 дугаар тушаалаар батламжлуулснаар банк, санхүүгийн байгууллагуудад хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт татах, иргэдэд тогтмол хугацаат хүүгийн орлого бүхий эрсдэл харьцангуй багатай хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн санал болгох боломжийг нээж, эрх зүйн орчинг бүрдүүлсэн.


Арилжааны журмын нэмэлт өөрчлөлт

Үнэт цаасны тооцооны T+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт хийх зарчимд 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөр шилжсэнтэй холбогдуулан арилжааны хэлцлийг баталгаажуулах болон алдаатай хэлцлийг цуцлах талаар МХБ-ийн “Арилжааны журам”-д нэмэлт өөрчлөлт оруулан 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр СЗХ-оор батламжлуулсан.






НИЙТ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН



ХУВЬЦААНЫ АРИЛЖАА





КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

2020 оны 6 дугаар сард “Лэндмн ББСБ” ХК-ийн нийт 50,000 ширхэг буюу 5.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, жилийн 17%-ийн хүүтэй өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд амжилттай арилжиж, 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөс уг бондын хоёрдогч зах зээлийн арилжааг нээснээр 1.1 сая төгрөгийн арилжаа хийгдээд байна.



“Сүү Бонд”-ын эргэн төлөлт 2018 оны 06 дугаар сарын 29-ны өдөр амжилттай хийгдэж, бондын хүүнд нийт 1.05 тэрбум төгрөгийг нийт 110 хөрөнгө оруулагчдад

төлсөн.
630 сая
төгрөг

Компанийн бондын арилжаа хийгдээгүй

5.0
тэрбум
төгрөг

2018 оны эхний хагас

2019 оны эхний хагас

2020 оны эхний хагас


■ Анхдагч зах зээлийн арилжаа

■ Хоёрдогч зах зээлийн арилжаа



ЗАХ ЗЭЭЛИЙН ИДЭВХЖИЛТ

2020 оны эхнээс дэлхий даяар тархаж буй **КОВИД-19** халдварт цар тахлын дэгдэлттэй холбоотой **зах зээлийн идэвх эрс буурсан** хэдий ч оны 6 дугаар сард МХБ-ийн анхдагч зах зээл дээр **“Бодь даатгал” ХК-ийн хувьцааны арилжааны захиалга 100% биелж**, **“ЛэндМН ББСБ” ХК-ийн бондын арилжааны захиалга 34.8%-аар давж биелсэн нь хөрөнгийн зах зээлд оролцогчдын сонирхол болон зах зээлийн эрэлт хэвээр байгааг харуулж байна.**





ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД




ТАЙЛАНТ ХУГАЦААНД ТОП-20 ИНДЕКСИЙН
ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ **17545.91 НЭГЖ** БАЙНА.
ТОП-20 ИНДЕКСИЙГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ
ХАРЬЦУУЛАХАД **4574.27 НЭГЖЭЭР** БУЮУ **22.02**
ХУВИАР БУУРЧ, 16208.94 НЭГЖ БОЛСОН
БАЙНА.

"ТОП-20" ИНДЕКСИЙН САГСЫГ ЖИЛД НЭГ УДАА
ШИНЭЧИЛДЭГ БӨГӨӨД 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД
ӨНГӨРСӨН ОНЫ ҮЗҮҮЛЭЛТЭЭР САГСЫГ ШИНЭЧЛЭХЭД ӨМНӨХ
САГСАД БАГТАЖ БАЙСАН 13 КОМПАНИ ХЭВЭЭР ҮЛДЭЖ,
ШИНЭЭР "ард кредит ББСБ" ХК, "инвескор ББСБ"
ХК, "монос хүнс" ХК, "түмэн шувуут" ХК, "шарын
гол" ХК, "улсын их дэлгүүр" ХК, "эрдэнэ ресурс
девелопмент корпорэйшн" хк-үүд
Нэмэгдсэн байна.



ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад **101.1 тэрбум төгрөгөөр** буюу **3.9 хувиар буурч**, 2 их наяд 500.6 тэрбум төгрөг болсон байна.




НИЙТ ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

МХБ ТӨХК нь 2020 оны эхний хагас жилд үйл ажиллагаанаас нийт **596.9 сая төгрөгийн** орлогыг олж, **694.5 сая төгрөгийн** зардал гаргаснаар **97.6 сая төгрөгийн алдагдалтай** ажилласан ба MIT цогц системийн элэгдэл, хорогдлын зардлыг хуримтлуулж тооцсоноор санхүүгийн тайланд нийт **402.5 сая төгрөгийн** татварын өмнөх алдагдлыг хүлээн зөвшөөрсөн байна.




НИЙТ ЗАРДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



МХБ ТӨХК нь тайлант хугацаанд байгууллагын удирдлагын болон нийт ажилтнуудын цалин хөлсний хэм хэмжээнд ямар нэг өөрчлөлт огт хийгээгүй бөгөөд холбогдох хуулийн дагуу **КОВИД-19** халдварт цар тахлын үеийн татвар, **нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамрагдаагүй** болно. Үйл ажиллагааны бусад зардлын тухайд **тэвчиж болох бүхий л зардлыг тэвчиж** ажилласнаар зардлыг өмнөх оны мөн үеэс **20%**-аар бууруулж ажилласан.



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.



“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК
Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар хот, Монгол Улс
Факс: (976)-11-325 170
Веб хуудас: www.MSE.mn